

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

АУДИТЫН КОД: БУА-2021/01-ШТА-ГА

УТХО-аар хэрэгжсэн барилга байгууламж, их засвар тоног төхөөрөмжийн ажлыг хүлээж авах комиссын үйл ажиллагаа хангалтгүй, дотоод хяналт сул, зарим тоног төхөөрөмж нийлүүлсэн ажлын үр дүнг тооцох боломжгүй байна.

БУЛГАН АЙМАГ 2021 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
Аудитор Б.Энхтөр
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

БУА-2021/01-ШТА-ГА

АГУУЛГА

| | |
|---|-----------|
| Товчилсон үгийн тайлбар..... | 4 |
| Хүснэгтийн товъёг..... | 5 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл..... | 6 |
| БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨГДСӨН БАЙНА..... | 8 |
| А.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж нийт 106775.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл арга хэмжээний жагсаалтыг хүргүүлэн ажиллажээ..... | 8 |
| А.1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2020 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд чиглэсэн байна..... | 8 |
| А.1.2 Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ салбарын бодлого, ТЭЗ-дын саналд үндэслэсэн боловч ирүүлсэн төсөл арга хэмжээний 61 ажлын санал нь зураг төсөвгүй ажлын санал ирүүлжээ..... | 8 |
| А.1.3 Аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлуудыг орон нутаг, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлж Сангийн яаманд 106755.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 94 төсөл арга хэмжээний саналыг хүргүүлэн ажилласан ч жагсаалтад тусгагдаагүй ажлын эрх шилжиж ирсэн байна..... | 8 |
| А.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх ажил хууль, дүрмийн дагуу иж бүрэн хийгдээгүй байна..... | 9 |
| А.2.1 Барилга байгууламж, их засварын ажлын зураг төсөл зохиох, ажлын даалгавар боловсруулсан нь салбарын бодлого, хэрэгцээ шаардлагад нийцсэн, зураг төсөв, ТЭЗҮ-г боловсруулж ажиллажээ..... | 9 |
| А.2.2 Зохиогчийн хяналт хийх гэрээний дагуу талбар дээр хяналт хийх ажлын хуваарь гаргаж ажиллаагүй байна..... | 9 |
| А.2.3 Барилга, байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, зохиох дүрмийн дагуу иж бүрэн магадлал хийлгээгүй зөвхөн төсөвт магадлал хийлгэжээ..... | 9 |
| А.3 Төсөл арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг ханган ажиллажээ..... | 10 |
| А.3.1 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн зарим шаардлагыг ханган ажилласан ч Сангийн яам 4 ТАХ-ний санхүүжилтийг эхний онд 21-33 хувиар баталсан нь тэнцүү хуваарилалт хийж батлаагүй байна..... | 10 |
| А.3.2 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд хяналт тавьж цахимд мэдээллийг мэдээлэн ажилласан байна..... | 10 |
| А.3.3 Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулсан байна..... | 10 |
| А.3.4 Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулаагүй байна..... | 10 |
| Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 26 төсөл, арга хэмжээ хэрэгжиж 2020 онд 18 төсөл арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж 8 төсөл арга хэмжээ нь он дамнасан байна..... | 10 |
| Б.1 Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан байна..... | 10 |
| Б.1.1 Төсөв, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна...10 | 10 |
| Б.1.2 ТАХ-г тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулсан боловч төсөл арга хэмжээний эрх шилжиж ирснээс 1 сараас 2 сарын дараа тендер шалгаруулалт явагдсан байна..... | 11 |
| Б.1.3 Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан ажилласан боловч үнэлгээний хорооны зарим гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах зөвшөөрлийн баримт үйлдээгүй дутуу байна..... | 11 |
| Б.1.4 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулжээ..... | 11 |

| | |
|--|--------------|
| Б.1.5 ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнажээ..... | 11 |
| Б.2 Тухайн онд хэрэгжсэн ТАХ-ний ажлуудаас 5 ажил нь гэрээний хугацаа хэтэрч 5.1 сая төгрөгийн алданги суутган тооцжээ..... | 11 |
| Б.2.1 Тухайн онд хэрэгжсэн ТАХ-ний ажлуудаас 5 ажил нь гэрээний хугацаа хэтэрч 5.1 сая төгрөгийн алданги суутган тооцжээ..... | 11 |
| Б.2.2 Гүйцэтгэгчээс хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авч байгаа ч өгсөн үүрэг даалгавар нь хугацаандаа хэрэгжээгүй байна..... | 11 |
| Б.2.3 Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжөөс 430.4 сая төгрөгийн эргэн төлөлтөөр олгосон тоног төхөөрөмжийг эргэн төлөлтийн хуваарь гарган эзэнжүүлэх, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж ажиллаагүй тул үр дүнг нь тооцох боломжгүй байна..... | 12 |
| Б.2.4 Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим нэг ажил нь ажил гүйцэтгэх графикийн дагуу хийгдээгүй, ажлын гүйцэтгэл дутуу байхад хийснээр акт үйлдэж 100.0 сая төгрөгийн санхүүжилт илүү олгожээ..... | 13 |
| Б.3 ТАХ –ний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлага үүсэж байна..... | 14 |
| Б.3.1 ТАХ-н хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтыг шат шатандаа хийж ажилласан ч зарим ажлын гүйцэтгэлд тавьсан хяналт сул байна..... | 14 |
| Б.3.2 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгож ажиллажээ..... | 14 |
| Б.3.3 Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон ТЕЗ-дын дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан ч зарим ажлууд дээр үр нөлөө бага гэж дүгнэгдэж байна..... | 14 |
| Б.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гаргасан шийдвэрийг үр дүнтэй гэж үзэж байна..... | 15 |
| Б.4.1 Тухайн онд 9 төсөл арга хэмжээний үлдэгдэл 27.7 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулан ажиллажээ..... | 15 |
| Б.4.2 2020 онд ашиглалтад орсон 2 барилга байгууламжийг хүлээн авч санхүүгийн бүртгэлд тусгаж, бүрэн хүчин чадлаараа нь ашиглаж байгаа ч их засвараар хийгдсэн тавилга эд хөрөнгийг орлогод аваагүй зөрчил илэрлээ..... | 16 |
| Дүгнэлт..... | 16-17 |
| Зөвлөмж..... | 17 |
| Мэдэгдэл..... | 17 |

Товчилсон үгийн тайлбар

| | |
|-------------|---|
| УТХО | Улсын төсвийн хөрөнгө оруулалт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ХОХБТХ | Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс |
| ТБОНӨХБАҮХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ХХААХҮ | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэл |
| ХНХ | Хөдөлмөр нийгмийн хамгаалал |
| БХБ | Барилга хот байгуулалт |
| БХТ | Барилга хөгжлийн төв |
| ЗТБХБГ | Зам тээвэр барилга хот байгуулалтын газар |
| ТХОТСХТЖ | Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналтын журам |
| ОНӨГ | Орон нутгийн өмчийн газар |
| БХБ | Барилга хот байгуулалт |
| ТӨХ | Төсөл арга хэмжээ |

Хүснэгтийн товьёг

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|-----------|--|-----------------|
| Хүснэгт 1 | Жагсаалтад тусгаагдаагүй төсөл арга хэмжээний нэрс | 8-9 |
| Хүснэгт 2 | Магаадлал хийгээгүй ажлын нэрс | 9 |
| Хүснэгт 3 | Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан үлдээгдэл | 15 |

Зургийн товьёг

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---------|--|-----------------|
| Зураг 1 | УТХО-ын сайдын баацны дүнг графиктаар | 10 |
| Зураг 2 | Дутуу ажлын зураг | 12 |
| Зураг 3 | Физикийн кабинетын тохижилт | 13 |
| Зураг 4 | Гэрээ хийгдээгүй тоног төхөөрөмж | 13 |
| Зураг 5 | Баян-Агт сумын ЗДТГ-ын барилгын суурь | 14 |
| Зураг 6 | Баян-Агт сумын ЗДТГ-ын барилгын хана өрснөөр авсан | 14 |
| Зураг 7 | Ашиглалтад орсон барилга байгууламж | 16 |

| | |
|---|---|
| Аудит хийх үндэслэл, бүрэн эрх | Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.</p> |
| Аудитын зорилт | <p>Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцууллага иргэд олон нийтэд мэдээлэхэд зорилт чиглэгдэнэ.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх.- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх. |
| Аудитын хамарсан хүрээ | <p>Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд санхүүжүүлэхээр баталсан 1346 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв болон бусад байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулна.</p> |
| Аудитын хязгаарлалт | |
| Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт | <p>Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шапгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнууд, судлаач, шинжээч нартай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, төрийн захиргааны байгууллага, аймаг нийслэлийн Засаг дарга түүний харьяа байгууллагын улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, захиалагч гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэл, хяналт, санхүүжилтийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх горимыг хэрэгжүүлэх, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.</p> |
| Аудитын бүрэлдэхүүн, хугацаа | <p>Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор П.Мөнхтуяа, аудитор Б.Энхтөр нар хийж гүйцэтгэлээ.</p> <p>Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл ажлын 35 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайланг хавсралт судалгааны хамт 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр ҮАГ-т, аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-т тус тус хүргүүлэн ажилласан болно.</p> |

Хүндрэл бэрхшээл

Аудит хийх ажлын хоног боломжийн боловч санхүүгийн аудит болон судалгааны ажилтай байсан тул зарим үед ажлын ачаалал их байсан болно.

БҮЛЭГ А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨГДСӨН БАЙНА.

А.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж нийт 106775.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл арга хэмжээний жагсаалтыг хүргүүлэн ажиллажээ.

А.1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2020 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд чиглэсэн байна.

УТХО-аар 2020 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулахдаа Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн 2020 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу аймаг, сум орон нутагт нэн шаардлагатай, шинээр барих барилга байгууламж, их засвар, гэрэлтүүлэг, шугамын ажлуудыг төлөвлөхдөө төсвийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйл, хөгжлийн бодлого, төлөвлөлт, удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмууд, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам"-ын 7 дахь заалтын тавигдах шаардлагуудыг үндэслэн аймаг орон нутагт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүдийг салбар салбарын хэмжээнд хэлэлцэн төлөвлөжээ.

Үүнд: Барилгын их засварын ажлуудаас эрүүл мэндийн салбарыг авч үзвэл 601.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 их засварын ажлыг эхлүүлсэн байна.

А.1.2 Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ салбарын бодлого, ТЭЗ-дын саналд үндэслэсэн боловч ирүүлсэн төсөл арга хэмжээний 61 ажлын санал нь зураг төсөвгүй ажлын санал ирүүлжээ.

Аймгийн хэмжээнд УТХО-аар 2020 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ажлуудын саналыг сум орон нутгийн 24 төсөвт байгууллагуудаас нийт 128492.2 сая төгрөгийн өртөгтэй 141 төсөл арга хэмжээний санал ирсэн нь салбар, салбарын бодлого, зорилт, хөтөлбөр, үр дүн, тооцоо судалгаанд тулгуурлан дутагдаж байгаа шаардлагатай барилга, байгууламж, тоног төхөөрөмж, их засвар, шугамын ажлуудыг жагсаан аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэн ажилласныг үзэхэд шаардлага хангахгүй зураг төсөвгүй, төсөвт өртөггүй 61, зураг төсөв нь хийгдэж дуусаагүй 3 төсөл арга хэмжээний ажлуудын саналыг тус тус ирүүлсэн байна.

Ирүүлсэн төсөл арга хэмжээний саналуудыг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах тайлагнах журам"-ын 3.2 дахь заалтад тусгагдсаны дагуу сонгон шалгаруулалт болон тооцоо судалгаатай, төсөвт өртөг, зураг төсөвтэй шаардлага хангасан төсөл арга хэмжээний ажлуудыг шийдвэрлүүлэхээр сонгон ажлыг зохион байгуулан ажиллажээ.

А.1.3 Аймагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлуудыг орон нутаг, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлж Сангийн яаманд 106755.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 94 төсөл арга хэмжээний саналыг хүргүүлэн ажилласан ч жагсаалтад тусгагдаагүй 3 ажлын эрх шилжиж ирсэн байна.

Аймаг сум, орон нутгийн ТЭЗ-ийн ирүүлсэн 2020 оны төсөл арга хэмжээний ажлуудаас зураг төсөв, ТЭЗҮ-лэлтэй, магадлал хийлгэсэн, шаардлагад нийцсэн төсөл арга хэмжээний ажлыг эрэмбэлэн нийт 106755.9 сая төгрөгийн өртөгтэй 94 төсөл арга хэмжээний ажлуудыг Сангийн яамны хөрөнгө оруулалтын программд мэдээлснээс 14222.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2020 онд 6699.8 сая төгрөгийн эрх аймагт шилжин ирсэн байна.

УТХО-аар хэрэгжүүлэх 94 төсөл арга хэмжээг эрэмбэлэн хүргүүлснээс барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн ажлуудаас жагсаалтад тусгагдаагүй 3 төсөл арга хэмжээний ажлын эрх шилжин ирүүлжээ.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

| № | Төсөл арга хэмжээний нэр | Төсөвт өртөг /сая.төг/ | Хүснэгт 1 |
|---|--------------------------------------|------------------------|------------------------------------|
| | | | Тухайн онд санхүүжих дүн /сая.төг/ |
| 1 | Могод сумын ЭМТ-ийн их засварын ажил | 50.0 | 50.0 |

| | | | |
|-----------------|--|--------------|--------------|
| 2 | Булган сумын соёлын ордонд шаардлагатай цахилгаан хөгжим худалдан авах | 10.0 | 10.0 |
| 3 | 3-р сургуульд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах | 5.0 | 5.0 |
| Нийт дүн | | 105.0 | 105.0 |

Дээрх хүснэгтээс үзэхэд шаардлагатай төсөл арга хэмжээг жагсаалт боловсруулан холбогдох яамдад хүргүүлж байгаа ч жагсаалтад ороогүй төсөл арга хэмжээг батлан ирүүлж байгаа нь орон нутаг болон иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төсөл арга хэмжээг батлахгүй өөрчилж батлах магадлалтай байна.

А.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх ажил хууль, дүрмийн дагуу иж бүрэн хийгдээгүй байна.

А.2.1 Барилга байгууламж, их засварын ажлын зураг төсөл зохиох, ажлын даалгавар боловсруулсан нь салбарын бодлого, хэрэгцээ шаардлагад нийцсэн, зураг төсөв, ТЭЗҮ-г боловсруулж ажиллажээ.

Шинээр хэрэгжсэн барилга байгууламжийн 4997.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 5 төсөл арга хэмжээний ажлуудаас 4 төсөл арга хэмжээний ажлууд нь өөрийн байгууллагын газар дээр, 1 буюу ахмадын өргөөний барилга байгууламжийн газрын зөвшөөрлийг олгох тухай захирамж 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдийн А/48 тоот албан бичгээр аймгийн ЗДТГ-т эзэмшүүлэхээр гаргажээ.

А.2.2 Зохиогчийн хяналт хийх гэрээний дагуу талбар дээр хяналт хийх ажлын хуваарь гаргаж ажиллаагүй байна.

Барилга байгууламжийн болон их засвар, гэрэлтүүлгийн ажлуудад зураг төсөл, зохиогчийн хяналт хийх гэрээ хийж ажиллаж байгаа ч төсөл арга хэмжээний ажлуудад зохиогчийн хяналт хийх гэрээний 2.3.3¹-т тусгагдсаны дагуу хяналт хийх хуваарийг гаргаж ажиллаагүй, ажлын талбар дээр 1-2 удаа хяналт хийсэн ажлын тайлан болон нэгдсэн дүгнэлтийг үндэслэн зураг төсөв, зохиогчийн хяналтын зардлыг нийт 73.5 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 38.9 сая төгрөгийг олгосон байна.

Цаашид зохиогчийн хяналт хийх ажлын хуваарийг батлуулж хуваарийн дагуу хийсэн ажлын тайлан, дүгнэлтээр зохиогчийн хяналтын зардлыг олгож байх шаардлагатай байна.

А.2.3 Барилга, байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, зохиох дүрмийн дагуу иж бүрэн магадлал хийгээгүй, зөвхөн төсөвт магадлал хийлгэжээ.

Аймгийн хэмжээнд нийт 26 ажлын эрх шилжиж ирснээс өмнөх онуудын 4 төсөл арга хэмжээний ажлаас гадна 22 төсөл арга хэмжээний зураг төсөвтэй танилцахад 4073.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 барилга байгууламжийн ажлын зураг төсөвт магадлал хийлгэсэн боловч 3 барилга байгууламж, их засварын ажлуудын зураг төсөвт магадлал хийгээгүй нь барилгын тухай хуулийн 25.2.1², 25.2.3³, барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, магадлал хийх дүрмийн 6.3⁴ гэсэн заалтуудыг мөрдлөг болгож ажиллаагүй, тухайн төсөл арга хэмжээний төсөвт магадлал хийлгээд зурагт магадлал хийлгээгүй гэсэн тайлбарыг өгч байгаа нь тухайн барилга байгууламж, засварын ажлууд иж бүрэн чанартай хийгдэхгүй, ажлын дунд өөрчлөлт орох эрсдэл дагуулах магадлалтай байна.

Магадлал хийгдээгүй их засварын ажлуудыг хүснэгтээр харуулбал:

| № | Төсөл арга хэмжээний нэрс | Гэрээний дүн /сая.төг/ | Тухайн онд санхүүжсэн дүн /сая.төг/ |
|-----------------|--|------------------------|-------------------------------------|
| 2 | Дашинчилэн сумын ЭМТ-ийн барилгын их засвар | 142.9 | 142.9 |
| 3 | Нэгдсэн эмнэлгийн ариутгалын тасгийн их засварын ажил | 141.1 | 141.1 |
| 4 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Булган сум, 3 дугаар цэцэрлэг/ | 905.0 | 200.0 |
| Нийт дүн | | 1189.0 | 1189.0 |

Цаашид шинээр хэрэгжиж байгаа барилга байгууламжийн зураг төсөвт холбогдох хууль, дүрмийн дагуу иж бүрэн магадлал хийлгэж ажиллах шаардлагатай байна.

¹ Гүйцэтгэгч нь барилга дээр ажиллах хяналт хийх хуваарийг захиалагчтай тохиролцон гаргаж ажиллана. Уг хуваарь нь энэ гэрээний хавсралт бөгөөд салшгүй хэсэг байна

² Газар хөдөлгөөний долоо ба түүнээс дээш багшлын бүсэд баригдах энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, инженерийн тооцоо, өртгийн төсөв

³ Барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд;

⁴ Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан зураг төсөлд заавал магадлал хийнэ

А.3 Төсөл арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилтийг ханган ажиллажээ.

А.3.1 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн зарим шаардлагыг ханган ажилласан ч Сангийн яам 4 ТАХ-ний санхүүжилтийг эхний онд 21-33 хувиар баталсан нь тэнцүү хуваарилалт хийж батлаагүй байна.

Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулахдаа хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан ТАХ-г сонгон шалгаруулж төлөвлөн ажиллаж байгаа ч Сангийн яам ТАХ-ний төсвийг хуваарилан батлахдаа шинээр хэрэгжүүлэх 2 жилийн хугацаанд баригдах 4 барилга байгууламжийн санхүүжилтийг эхний онд 21-33 хувиар олгохоор тооцоолон баталсан нь төсвийн тухай хуулийн 29.3.5⁵ заасны дагуу тэнцүү хуваарилалт хийж батлаагүй байна.

А.3.2 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд хяналт тавьж цахимд мэдээллийг мэдээлэн ажилласан байна.

ТЭЗ болон төсөвт байгууллагуудын ТАХ-ний саналыг үндэслэн төлөвлөж шаардлага хангасан зураг төсөвтэй, магадлал хийлгэсэн, ТЭЗҮ техникийн нөхцөл, ажлын даалгавар зэргийг хянан үзэж, үр дүнтэй хэрэгжих ТАХ-г жагсаан эрэмбэлсний дагуу Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын системд мэдээллийг цахимаар оруулан ажиллажээ.

А.3.3 Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулсан байна.

Шинээр хэрэгжсэн ТАХ-ний ажлуудын эрх аймагт 2020 оны 01 сараас 02 сарын хооронд шилжин ирж, ХАА болон тендер шалгаруулах үйл ажиллагаа нь 3 сараас 4 сарын хооронд явагдаж, гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулах, санхүүжилтийг олгох тухай захирамж 2020 оны 4 сараас 8 саруудын хооронд гарч гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажилласан нь ТАХ-г хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцсон байна.

А.3.4 Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулаагүй байна.

Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 26 төсөл, арга хэмжээ хэрэгжиж 2020 онд 18 төсөл арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж 8 төсөл арга хэмжээ нь он дамнасан байна.


Б.1 Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан байна.

Б.1.1 Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

УТХО-аар 2020-2021 онд хийгдсэн төсөл арга хэмжээ нь Монгол улсын төсвийн тухай хуулиар батлагдсан 14272.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 6699.8 сая төгрөгийн санхүүжих 26 төсөл арга хэмжээг 2020 оны 02 дугаар сарын 05-аас 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн тушаал шийдвэрээр аймагт хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна.

Графикаар харуулбал:

/зураг-1/



⁵ шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож густал

Төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад аймгийн Засаг даргын захирамжаар томилсон үнэлгээний хороо тендер зарлаж гэрээ байгуулах хүртэлх ажлыг зохион байгуулж сонгон шалгаруулалтыг хийхэд 14-30 хоногийн хугацаа шаардсан нь хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжиж ирсэн гэж үзлээ.

Б.1.2 ТАХ-г тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулсан боловч төсөл арга хэмжээний эрх шилжиж ирснээс 1 сараас 2 сарын дараа тендер шалгаруулалт явагдсан байна.

2020-2021 онд 26 төсөл арга хэмжээ хэрэгжсэнээс 18 ажил нь тайланд онд хэрэгжиж ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46.1.1⁶ үнэлгээний хороо байгуулж ажил тус бүрээр тендер зарлаж ХАА-ны үнэлгээгээр үнэлж ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46.1.2⁷, 46.1.3⁸, 47.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн сонгон шалгаруулалтыг хийсэн боловч зарим нэг төсөл арга хэмжээний гүйцэтгэх гэрээг 1-2 сарын дараа хийсэн байна.

Б.1.3 Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан ажилласан боловч үнэлгээний хорооны зарим гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах зөвшөөрлийн баримт үйлдээгүй дутуу байна.

УТХО-аар хийгдсэн төсөл арга хэмжээг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 46.1.1, 46.1.3, 47.4 заалтын дагуу зохион байгуулж сонгон шалгаруулалтыг хийсэн байна.

Булган сумын Хог хаягдлын төвлөрсөн цэг орчмын бохирдлыг бууруулах төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгуулах үнэлгээний хороог Засаг даргын А/288 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг үнэлгээний хорооны 3 гишүүн мэдэгдээгүй, Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 330 тоот тушаалын 1 дүгээр хавсралт Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгээр мэдээлээгүй байгаа нь ашиг сонирхлын зөрчилтэй буюу гишүүнээр ажиллахыг зөвшөөрөөгүй гэж үзэж байна.

Б.1.4 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулжээ.

УТХО-аар шинээр 20 төсөл арга хэмжээ хэрэгжиж ажил тус бүрээр тендерийн жишиг баримт бичиг үүсгэж гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэж Сангийн сайдын 330 дугаар тушаалаар баталсан 1, 2, 3 дугаар хавсралтаар баталсан маягт, зааврын дагуу, нээлттэй тендер шалгаруулалтын журмаар тендерийн бичиг баримтыг боловсруулан холбогдох веб сайтад тендерийн урилгыг нээлттэй байршуулж хүчинтэй хугацаанд ирүүлсэн хамгийн сайн тендерийг сонгон шалгаруулж үнэлгээний хороо нь аймгийн Засаг даргад зөвлөмжийг албан тоотоор хүргүүлэн ажиллажээ.

Б.1.5 ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнажээ.

ОНӨГ нь 2020 онд УТХО-аар хэрэгжсэн 20 төсөл арга хэмжээний ХАА-ны тайлан мэдээг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан журамд заасан 4-7 маягтын дагуу хагас, бүтэн жилээр хугацаандаа тайлагнан ажиллажээ.

Б.2 Тухайн онд хэрэгжсэн ТАХ-ний ажлуудаас 5 ажил нь гэрээний хугацаа хэтэрч 5.1 сая төгрөгийн алданги суутган тооцжээ.

Б.2.1 Тухайн онд хэрэгжсэн ТАХ-ний ажлуудаас 5 ажил нь гэрээний хугацаа хэтэрч 5.1 сая төгрөгийн алданги суутган тооцжээ.

Тухайн онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 3151.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ажлуудын гүйцэтгэгч компаниуд гэрээний дагуу хугацаандаа ажлыг дуусаагүй, хугацаа хэтэрсэн тул 5.1 сая төгрөгийн алдангийг нийт санхүүжилтээс нь хасаж тооцсон байна.

Мөн төсөл арга хэмжээний зарим ажлуудын гэрээний хугацааг сунгасан боловч тухайн байгууллагын хүсэлтийг үндэслээгүй гэрээний хугацааг сунгасан байна.

Б.2.2 Гүйцэтгэгчээс хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авч байгаа ч өгсөн үүрэг даалгавар нь хугацаандаа хэрэгжээгүй байна.

⁶ энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах

⁷ үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж гарсан зөрчлийг арилгуулах

⁸ үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр


Аймгийн хэмжээнд 26 төсөл арга хэмжээ хэрэгжиж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж аймгийн Засаг даргын захирамжаар улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлсэн барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авахдаа ихэвчлэн улсын комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авах саналыг үндэслэн хүлээн авч ажиллажээ.

Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлууд нь зураг, төсвийн дагуу хийгдэж, гүйцэтгэгч компани хугацаандаа хүлээлгэн өгч байгаа ч зарим төсөл арга хэмжээний ажлуудыг хүлээж авах комисс үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан ч одоог хүртэл дутуу ажлуудыг хийж гүйцэтгээгүйг цар тахалтай холбогдуулаад хийгдээгүй гэсэн тайлбарыг өгч байна.

Тухайлбал: Могод сумын сургуулийн гал тогооны их засварын ажил, Бугат сумын сургуулийн дотуур байрны барилгын ажлуудад үүрэг даалгаврын биелэлтийн ажлууд хийгдээгүй зөрчилд албан шаардлага бичлээ.

Бугат сумын сургуулийн дотуур байрны барилгын дутуу ажлын зураг

/зураг-2/



Халтирахгүй резин наах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний орох гарах шат хийх, явган зам хийх, сангийн хоолой холбох

Могод сумын сургуулийн барилгын гал тогооны их засварын дутуу ажлын зураг



Дүүжин таазны зарим хэсэг дутуу гадна бохир шугамын сүлжээнд таг хийх хулдаас дутуу дэвссэн байдал

Б.2.3 Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжөөс 430.4 сая төгрөгийн эргэн төлөлтөөр олгосон тоног төхөөрөмжийг эргэн төлөлтийн хуваарь гарган эзэнжүүлэх, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж ажиллаагүй тул үр дүнг нь тооцох боломжгүй байна.


УТХО-аар тоног төхөөрөмж худалдан авах шаардлагатай 495.4 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээний ажил хэрэгжсэнээс 13.1 хувийн ажил нь үр дүнтэй хэрэгжиж, 86.9 хувийн ажил үр дүн тооцох боломжгүй байна.

Тухайлбал: Шинэ хөдөө-хөгжил ОНӨААН нь 3 багцаар тендер зарлагдаж худалдан авсан 430.4 сая төгрөгийн хонь хяргах машин, төмс хүнсний ногоо тариалах төхөөрөмж, бог малыг ангилан ялгах бүрэн тоноглогдсон хашаа, жимс хүнсний ногоо, хатаагч төхөөрөмж зэргийн тоног төхөөрөмжийг 36 иргэнд олгохоор сумдын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн боловч эргэн төлөлтөөр хийгдэх гэрээ байгуулж эзэнжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаагүй, комисс томилсон тушаалын хэрэгжилт хангалтгүй зөрчил илэрсэн тул албан шаардлага бичлээ.

Үр дүнтэй хэрэгжсэн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжийн ажлыг зургаар харуулбал:

Булган сумын 3-р сургуулийн физикийн кабинетын тохижилт

/зураг-3/



Үр дүнг тооцох боломжгүй эргэн төлөлтийн хуваарь гарган гэрээ байгуулж ажиллаагүй тоног төхөөрөмжийг зургаар илэрхийлбэл:

/зургаг-4/



Малын тоноглогдсон хашаа



мотор



хонь хяргагч төхөөрөмж



Жимс хүнсний ногоо хатаагч



төмс хүнсний ногоо тариалах төхөөрөмж



Тоног төхөөрөмжийг 2020 оны 06 сарын 06-ны өдрөөс 26-ны өдрийн хооронд сумдын ЗДТГ-т хүлээлгэн өгснөөс хойш одоог хүртэл ашиглагдаагүй, гэрээ хийх эргэн төлөлтөөр худалдан авах иргэд аж ахуйн нэгжийг сонгож ажиллаагүй байна.

Б.2.4 Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим нэг ажил нь ажил гүйцэтгэх графикийн дагуу хийгдээгүй, ажлын гүйцэтгэл дутуу байхад хийснээр акт үйлдэж 100.0 сая төгрөгийн санхүүжилт илүү олгожээ.

УТХО-аар хэрэгжсэн барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн ажлууд зориулалтын дагуу хийгдэж ашиглалтад орж байгаа ч зарим ажлын гүйцэтгэл мэдээ, тайлан хяналт хийсэн явц гүйцэтгэлийн баримтыг түүвэрлэн шалгахад Баян-Агт сумын ЗДТГ-ын барилгын ажлын гүйцэтгэлийг 2020 онд 200.0 сая төгрөгөөр санхүүжихээр баталж захирамж гарч "Мэйнспринг" ХХК-тай гэрээ байгуулан ажилласан ч тухайн онд хийгдэх шороо, суурийн, хана болон хамар ханы ажлуудыг хийхээр ажлын график байгуулан ажилласан хэрнээ бодит байдалд ажлын гүйцэтгэл 50 хувь дутуу байхад дээрх ажлуудыг бүрэн хийснээр гүйцэтгэл, тайлан, мэдээ гаргаж 200.0 сая төгрөгийг олгож, 100.0 сая төгрөгийн санхүүжилт илүү, барилгын ажлын гүйцэтгэлд тавих шат шатны хяналт сул байна.

Баян-Агт сумын ЗДТГ-ын барилгын бодит гүйцэтгэлийн зургийг 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаарх байдал

/зураг-5/



Барилгын хана өрөөгүй байхад өрснөөр акт үйлдсэн байдал

/зураг-6/



Цаашид барилга байгууламжийн ажилд тавих шат, шатны хяналтыг сайжруулах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Б.3 ТАХ –ний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлага үүсэж байна.

Б.3.1 ТАХ-ний хэрэгжилтэд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналтыг шат шатандаа хийж ажилласан ч зарим ажлын гүйцэтгэлд тавьсан хяналт сул байна.

Тухайн онд хэрэгжих төсөл арга хэмжээний ажлуудыг төлөвлөх, тендер шалгаруулалт, санхүүжилт олгох, барилга байгууламж, их засвар тоног төхөөрөмжийн ажлуудын явц, гүйцэтгэлд хийх шат шатны хяналтыг хугацаанд нь ажлын график гарган, ажлын тайлан мэдээ, ил далд ажлын гүйцэтгэлийг баримтжуулан ажиллан, ажлын явцад зөвлөмж зөвлөгөө өгч ажилласан ч аудитын явцад үүссэн зөрчлөөс үзэхэд зарим ажлын гүйцэтгэлд хяналтыг сайжруулах шаардлага үүсэж байна.

Б.3.2 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгож ажиллажээ.

УТХО-аар 2020-2021 онд 14272.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 төсөл арга хэмжээнээс 2020 онд хэрэгжүүлэхээр аймагт 6699.8 сая төгрөгийн эрх шилжиж ирснээс нийт гэрээг 6465.5 сая төгрөгөөр байгуулж гүйцэтгэлээр 6155.8 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 309.7 сая төгрөгөөс он дамнасан ажлын гүйцэтгэл 280.6, барьцаа хөрөнгийн дансанд 29.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан гэрээний хавсралтаар санхүүжилтийн хуваарь, ГХБХБ, зохиогчийн, техник хяналтын зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримт болон төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээ, баримтыг үндэслэн санхүүжилтийг олгожээ.

Б.3.3 Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон ТЕЗ-дын дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан ч зарим ажлууд дээр үр нөлөө бага гэж дүгнэгдэж байна.

Аймагт хэрэгжсэн ТАХ-ний ажлуудад ТЕЗ болон ашиглагч байгууллага, сумдын иргэд барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн ажлуудад дотоод хяналт болон хөндлөнгийн хяналт хийж ажилласан ч ТАХ-гээр нэмэгдсэн хөрөнгийг өөрийн байгууллагад

орлого авч бүртгээгүй, эд хариуцагч нярав, нягтлан бодогчид актаар хүлээлгэн өгөөгүй зөрчлүүд илэрч байна.

Энэ нь тухайн онд хэрэгжсэн их засварын ажлуудаас зарим тоног төхөөрөмж, хөрөнгийг өөрийн эзэмшилд орлого авч бүртгээгүй зөрчил илэрч байгаа нь ажил хүлээлцэх комисст тухайн байгууллагын эд хариуцагчийг томилж ажиллаагүйгээс, мөн мэдээлэл дутуугаас хөрөнгө орлогодохгүй, орхигдуулах эрсдэл үүсэх магадлалтай байна.

Тухайлбал: Могод сумын сургуулийн гал тогооны их засварын ажлаар хийгдсэн 360.0 мянган төгрөгийн хаалга, 280.0 мянган төгрөгийн насос, 350.0 мянган төгрөгийн цэвэр усны сав зэргийг орлогод авч бүртгээгүй, мөн Нэгдсэн эмнэлгийн ариутгалын тасгийн их засварын ажлаар таазанд нүдэн гэрэл 81 ширхгийг 680.0, 12 ш модон хаалганы 1980.0, хулдаас 2523.9 мянган төгрөг буюу нийт 6173.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж аваагүй зөрчлүүд илэрсэн нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 16.10⁹ гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд УТХО-аар хэрэгжсэн ажлуудын комиссын бүрэлдэхүүнд тухайн байгууллагын эд хариуцагчийг томилж ашиглагч байгууллагын хяналтыг сайжруулах ажиллах шаардлагатай байна.

Б.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглах зорилгоор Засгийн газраас гаргасан шийдвэрийг үр дүнтэй гэж үзэж байна.

Б.4.1 Тухайн онд 9 төсөл арга хэмжээний үлдэгдэл 27.7 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулан ажиллажээ.

Тухайн онд 2375.2 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй 8 төсөл арга хэмжээний үлдэгдэл 27.7 сая төгрөгийг Монгол улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 430, 2020 оны ЗГ-ын 253 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулан мөрдөж ажиллажээ.

ЗГ-ын тогтоол гарсан нь төсөл арга хэмжээний батлагдсан санхүүжилтийг бүрэн олгох, дутуу орхигдсон барилга байгууламж, их засварын ажлууд хойшлогдохгүй царцаагдахаас урьдчилан сэргийлж гаргасан шийдвэр нь зөв гэж үзэж байна.

Төсөл арга хэмжээний барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

| | | | | /Хүснэгт-3/ |
|----------|---|----------------------------------|------------------------|---|
| № | Төсөл арга хэмжээний нэрс | Батлагдсан төсвийн дүн /сая.төг/ | Гэрээний дүн /сая.төг/ | Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан дүн /мян.төг/ |
| 1 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих, 75 ор /Булган, Гурванбулаг сум/ | 600.0 | 1004.0 | 18.7 |
| 2 | Спорт залны барилга /Булган, Хангал сум/ | 425.0 | 439.0 | 2.3 |
| 3 | Сумын эрүүл мэндийн төвийн их засвар /Могод сум/ | 50.0 | 49.3 | 0.4 |
| 4 | Баяннуур сумын ЭМТ-ийн барилгын их засварын ажил | 251.3 | 224.0 | 0.2 |
| 5 | Сургуулийн барилга 240 хүүхэд /Булган, Хутаг-Өндөр сум/ | 865.3 | 1125.5 | 0.7 |
| 6 | Сургуулийн барилгын засвар /Булган, Дашинчилэн сум/ | 55.6 | 55.6 | 4.0 |
| 7 | Сургуулийн барилгын сантехникийн засвар /Булган, Булган сум, ЭӨЦСургууль/ | 48.0 | 48.0 | 1.4 |
| 8 | Сургуулийн барилгын засвар /Булган, Хишиг-Өндөр сум/ | 80.0 | 73.8 | 0.03 |
| Нийт дүн | | 2375.2 | 3019.2 | 27.7 |

⁹ Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл арга хэмжээ тус бүрийн талаар дараах мэдээллийг агуулсан тайланг тогтмол гаргах бөгөөд санхүүгийн дүн тооцоог өөрийн байгууллагын жилийн тайланд тусгаж тайлагнана.

Б.4.2 2020 онд ашиглалтад орсон 2 барилга байгууламжийг хүлээн авч санхүүгийн бүртгэлд тусгаж, бүрэн хүчин чадлаараа нь ашиглаж байгаа ч их засвараар хийгдсэн тавилга эд хөрөнгийг орлогод аваагүй зөрчил илэрлээ.

УТХО-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний 26 ажлуудаас 2020 онд 2408.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Бугат сумын сургуулийн дотуур байр, 1500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хутаг-Өндөр сумын 240 хүүхдийн сургуулийн барилгын өргөтгөлийн ажлууд ашиглалтад орсныг холбогдох байгууллагууд санхүүгийн тайлан бүртгэлд орлого авч бүртгэсэн байна.

/зураг-7/



Хутаг-Өндөр сумын сургуулийн барилгын өргөтгөл



Бугат сумын сургуулийн дотуур байр

Аудитаар нийт 536.6 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 430.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 106.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- УТХО-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь нэгдсэн хөтөлбөр, нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй нийцсэн байна.
- ТЕЗ-дын ирүүлсэн ТАХ-ний саналаас 61 ТАХ нь зураг төсөвгүй ажлын санал ирүүлжээ.
- Сангийн яаманд 106755.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 94 төсөл арга хэмжээний саналыг хүргүүлэн ажилласан ч жагсаалтад тусгагдаагүй 3 ажлын эрх шилжин ирсэн байна.
- Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх ажил хууль, дүрмийн дагуу иж бүрэн хийгдээгүй зөвхөн төсөвт өртөгт магадлал хийлгэжээ.
- Зохиогчийн хяналт хийх гэрээний дагуу талбар дээр хяналт хийх ажлын хуваарь гаргаж ажиллаагүй байна.
- Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний санхүүжилтийг Сангийн яам батлахдаа 4 ТАХ-ний санхүүжилтийг эхний онд 21-33 хувиар баталсан нь тэнцүү хуваарилалт хийж батлаагүй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 26 төсөл, арга хэмжээ хэрэгжиж 2020 онд 18 төсөл арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж 8 төсөл арга хэмжээ нь он дамнасан байна.
- Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан ажилласан боловч үнэлгээний хорооны зарим гишүүд нь ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах зөвшөөрлийн баримт үйлдээгүй дутуу байна.
- Гүйцэтгэгчээс хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авч байгаа ч өгсөн үүрэг даалгавар нь хугацаандаа хэрэгжээгүй байна.
- Тухайн онд хэрэгжсэн их засварын ажлуудаас зарим хөрөнгө болон материалыг өөрийн эзэмшилд орлого авч бүртгээгүй зөрчил илэрч байгаа нь ажил хүлээлцэх комисст тухайн байгууллагын эд хариуцагчийг томилж ажиллаагүйгээс, мөн мэдээлэл дутуугаас хөрөнгө орлогодохгүй, орхигдуулах эрсдэл үүсэх магадлалтай байна.
- Гүйцэтгэгч компани нь тухайн барилга байгууламж, их засварын ажлуудын гүйцэтгэл дутуу хийгдсэн байхад хугацаандаа дууссанаар албан тоот хүргүүлж байгаа нь алдангиас зайлсхийсэн нэг хэлбэр болж байна.
- Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмжөөс 430.4 сая төгрөгийн эргэн төлөлтөөр олгосон тоног төхөөрөмжийг эргэн төлөлтийн хуваарь гарган эзэнжүүлэх, гэрээ

байгуулах ажлыг зохион байгуулж ажиллаагүй тул үр дүнг нь тооцох боломжгүй байна.

- Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим нэг ажил нь ажил гүйцэтгэх графикийн дагуу хийгдээгүй, ажлын гүйцэтгэл дутуу байхад хийснээр акт үйлдэж санхүүжилтийг 100.0 сая төгрөгөөр илүү олгожээ.
- Дээрх зөрчлүүдээс үзэхэд УТХО-аар хэрэгжсэн барилга байгууламж, их засвар тоног төхөөрөмжийн ажлыг хүлээж авах комиссын үйл ажиллагаа хангалтгүй, дотоод хяналт сул, зарим тоног төхөөрөмж нийлүүлсэн ажлын үр дүнг тооцох боломжгүй байна гэж дүгнэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Үүнд:

Нэг: Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ, ХОХБТХ-ийн дарга Д.Буманбаяр, СТСХ-ийн дарга Д.Батцогт нарт

1. Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний ажлуудыг ТЕЗ-аас хүлээн авахдаа зураг төсөвгүй, магадлалаар баталгаажуулаагүй ажлын санал ирүүлэхгүй байхаар чиглэл өгч ажиллах.
2. Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад орж байгаа барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.
3. Гүйцэтгэгч компаний ажлын тайлан мэдээг бодит гүйцэтгэлд үндэслэн үнэн зөв мэдээ тайлан гаргуулж санхүүжилтийг олгож алдаа зөрчлийг дахин давтахгүйгээр арга хэмжээ авч ажиллах.

Хоёр. Аймгийн ОНӨГ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Баттулгад

1. УТХО-аар хийгдсэн барилга байгууламж, их засварын ажлаар нэмэгдсэн хөрөнгийг байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүрэн орлогод авч байхаар чиглэл өгч хяналтыг сайжруулж ажиллах.

МЭДЭГДЭЛ:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж хэрэгжилт, үр дүнг 2021 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.МӨНХТУЯА

АУДИТОР

Б.ЭНХТӨР